

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ  
11 ДУГААР САРЫН МЭДЭЭ

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын захиалгыг 2020 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 3/1736 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж 10 дугаар сарын 22-ны өдөр олон нийтэд зарлаж, шалгалтад орох хүсэлтэй иргэдийн материалыг [khuvs gul.tu@csc.gov.mn](mailto:khuvs gul.tu@csc.gov.mn) хаягаар хүлээн авч, 10 дугаар сарын 29-ны өдөр шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтад бүртгүүлэхээр 17 иргэн материалаа ирүүлж тусгай болон ерөнхий шаардлагыг хангасан 11 иргэн 3 ажлын байранд тусгай шалгалтад орж 1 буюу 9,09 хувь шалгалтад тэнцэв.

Төрийн жинхэнэ албан тушаалын нөөц бүрдүүлэх Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2020 оны 11 дүгээр сарын 6, 7 ны өдрүүдэд зохион байгууллаа. Шалгалтад орох иргэдэд шалгалтад орох хуваарь, анхаарах зүйлс болон бусад мэдээллийн талаар танхимаар болон олон нийтийн сүлжээ, телевиз, радио, сонин сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан мэдээллийг түгээн ажиллаа.

Хөвсгөл аймагт төрийн албаны ерөнхий шалгалтад 703 иргэн бүртгүүлж, 506 иргэн шалгалтад орж, ерөнхий мэдлэгийн шалгалтад 195 иргэн, Монгол хэл, бичгийн шалгалтад 166 иргэн, Дүн шинжилгээ хийх чадварын шалгалтад 156 иргэн буюу 30,8 хувь нь шалгалтад тэнцсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ханх сумын Засаг даргын Тамгын газар шинэ байртай болов.

**Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2020 оны 11-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 8.6 тэрбум төгрөгний **1,751** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 10-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 9,688.1 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 11,765.1 сая төгрөг буюу 121.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2020 оны 10-р сарын мэдээгээр Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 85,938.4 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 68,678.1 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 88,535.0 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 3,186.2 сая төгрөг нь төсөвт байгууллагын

өөрийн орлогоос, 5,350.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 85,937.4 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 74,988.8 мянган төгрөг буюу 87.3 хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,669.3** сая төгрөг өмнөх сараас **56.0** сая төгрөгөөр өссөн.

Нийт өглөг **905.4** сая төгрөг өмнөх сараас **8.9** сая төгрөгөөр буурсан.

2020 оны 11 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 2870.4 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 103.2 сая төгрөгийн, шимтгэлийн орлого 100.1 хувиар биелүүлсэн байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2598	2591.1	99.7
Тэтгэмж	223.8	230.2	102.8
Үомшө	99.2	100.2	101
ЭМД	0,0	0,0	0,0
Ажилгүйдэл	50.1	52.1	104
Дүн	2971.1	2973.6	100.1

Тэтгэврийн даатгалын сангаас 19985 тэтгэвэр авагчид 6832.7 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 241 даатгуулагч 300,2 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 62 даатгуулагчдад 37.1 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 600.2 сая төгрөг байна.

Санхүү хяналт дотоод аудитын алба нь: 2020 оны 11 сарын байдлаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дагуу нийт 243 төсөвт байгууллагад хяналт шалгалт хийсэн ба Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл ус суваг, Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, сургуулийн өмнөх боловсролын хийгдэж байна.

#### **Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :**

Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учруулж буй хор, хөнөөлийг хянах, бууруулах зорилгоор 11 асуудлаар 189 объектод (78.5%) хяналт шинжилгээ

хийж шилэн хяналтын цахим мэдээллийн санд бүртгэсэн. Хяналт шинжилгээнд аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамруулснаар хүнсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хараат бус үнэн бодит шинжилгээний дүнгээр баталгаажуулах нөхцөл боломж бүрдэж байна.

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 50 асуудлаар урьдчилан сэргийлэх шалгалтыг хэрэгжүүлэхээр 820 объектыг хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн байна.

Үйлдвэрлэл ажил үйлчилгээ эхлэхээс өмнө аюулд эрсдэлийг хянах зорилгоор иргэдийн хүсэлтээр хянан баталгаажуулах үйл ажиллагааг 7 чиглэлээр 16 объектод баталгаажуулах хяналт хийгдсэн. Баталгаажуулах хяналт хийгдсэнээр стандартын шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээний тоо нэмэгдэж, аюулгүй байдал хангагдаж байна.

#### **Гэмт хэрэг зөрчлийн чиглэлээр.**

Аймгийн хэмжээнд бүгд гэмт хэрэг 10 дугаар сарын байдлаар 3356 буюу өмнөх оны мөн үеэс 181 гэмт хэрэг буюу 5.7%-аар өссөн дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд бүгд гэмт хэрэг 11 дүгээр сарын байдлаар 663 буюу өмнөх оны мөн үеэс 81 гэмт хэргээр буюу 10.9%- аар буурсан дүнтэй байна.

Зөрчил 288 буюу өмнөх оны мөн үеэс 27 зөрчлөөр буюу 10.3% -иар буурсан үзүүлэлттэй байна.

#### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

##### **Боловсролын чиглэлээр:**

Сургууль, цэцэрлэгүүд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 03 сарын 20-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”, удирдамжийн дагуу үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна.

Google classroom-ийг ашиглан сургуулийн захирлууд 35 (хүн), цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нар (54 хүн), сургалтын менежерүүдийн (83 хүн) онлайн ангийг идэвхжүүлэн мэдээ мэдээлэл, цаг үеийн ажлуудыг шуурхай явуулах зохион байгуулалтад орж ажиллаж байна.

ЕБС-ийн 1-11-р ангийн сургалтын хөтөлбөр, гарын авлагыг бүх сургуульд цахимаар хүргэж, теле хичээл үзэх боломжгүй хүүхдүүдэд хэвлэж хувилж өгөх

чиглэлээр үүрэгжүүлсэн. Теле хичээлийн хуваарийг аймаг, сум болон сургууль, цэцэрлэгт хүргэх, түгээх ажил тогтмол хийгдэж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 11 сарын 13-ны өдрийн А/592 захирамжийн дагуу хүүхдийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор судалгаа мэдээллийг шинэчлэн бүрдүүлж байна. Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн суурь үнэлгээ, мэдээлэл судалгааны сан бүрдүүлэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан үйл ажиллагаанд зөвлөмж өгч арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 875, хоол хүнсний тусламж, дэмжлэг шаардлагатай 1350 хүүхэд байна.

Хүүхэд хамгааллын хамтарсан багаар зорилтот өрхүүдэд чиглэсэн хүнс, түлээ түлшний тусламжид хамруулах, хөршийн холбоог сайжруулах, хүүхэд хамгааллын зөрчлийн мэдээллийг хүлээн авч хариу үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн цахим зөвлөгөө өгөх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зэрэг гарын авлага, брошурыг цахимаар болон цаасаар хэвлэн айл өрх, иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:**

“Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр 11 дүгээр сард нийт 48 хүнд үйлчилгээ үзүүлэн ажилласан ба үүнээс нийт хүүхэд 19 /эмэгтэй-13, эрэгтэй-6/ насанд хүрэгч 29 /эрэгтэй-8, эмэгтэй-21/ үйлчлүүлсэн байна. 9 дүгээр сараас 41.5%-аар үйлчлүүлэгчийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Долоо хоног бүрийн 5 дахь өдөр кейс хэлэлцүүлэг хийн тухай 7 хоногт үйлчлүүлсэн болон байрлаж байгаа иргэд, хүүхдийн асуудлыг мэргэжлийн баг хэлэлцэж хэвшсэн. Халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн утас 108-д 10 дугаар сарын 26-аас 11 дүгээр сарын 24-ний байдлаар нийт 19 дуудлага бүртгэгдсэн байна. Бүрэнтогтох 1, Баянзүрх 1, Төмөрбулаг 1, Ханх 1, Мөрөн сум 15 байна. Хандсан асуудал гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн. 19 дуудлагыг харьяа хамтарсан багт шилжүүлж, хяналтад авч, хариу үйлчилгээ үзүүлж байна.

Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, үр дүнд хүрсэн бодитой үйл ажиллагааг зохион байгуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу шилдэг эцэг эхийн зөвлөл шалгаруулах болзол гарган газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны 234 тоот албан бичгээр болзлыг хүргүүлж тайлан хүлээж авах ажил явагдаж байна.

Лхамхай хүүхдүүдийн хувьд 5 багц үнэлгээгээр эрсдэлтэй хүүхэд байхгүй бөгөөд боловсролд хамрагдалтын байдал: 1 хүүхэд ЕБС-ийн өөрийн сурч байсан 7-р ангид орсон, Бүрэнтогтох сумын ЕБС-ийн 11-р ангид 2 лхамхай орсон, 1 ламхай Мөрөний хүрээ Гандандаржаалин хийдэд орсон, 1 хүүхэд жолооны курс

суралцаж байгаа цаашид лам чиглэлээр суралцахаар байна. 2 ламхай одоогоор шийдгүй эцэг эхтэйгээ ярилцаж шийдвэр гаргахаар болов. Тухайн асуудлаар эцэг эх, асран хамгаалагч нар болон аймгийн БСУГ-тай хамтран ажиллаж байна.

Аймгийн ХДТ-ын “Эцэг эхийн зөвлөл”-тэй хамтран, гэр бүл, хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулсан байна. Аймгийн Хөгжимт драмын театрын албан хаагчдын хүүхдүүдийн хувь хүний хөгжил, төлөвшил, хандлагад оролцооны аргыг ашиглан дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол цэргийн нэгдсэн холбооны Хөвсгөл аймаг дахь салбар холбоотой хамтран 2020 оны 11 дүгээр сарын 1-ны өдөр “Миний гэр бүл-хайр” үйл ажиллагаа зохион байгуулав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Хөвсгөл аймаг дахь байгууллагуудын албан хаагчдын дундах спортын наадамд байгууллагаараа 2-р байр эзлэв.

24 сумын хамтарсан багуудтай холбогдож, аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа, хоол хүнс болон түлшний хомсдолд орж болзошгүй өрхийн судалгааг гаргаж, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай судалгааг тулган нэгтгэж, аймгийн Шуурхай штаб, ХХААГ, Улаан загалмайн хороо болон ЗГХА ГБХЗХГ-т тус тус хүргэсэн. Уг судалгаагаар 24 сумын 1090 өрх одоогийн байдлаар эрсдэлтэй байна. Эдгээр өрхүүдэд 2705 хүүхэд байгаа бөгөөд 887 нь хүнс, 622 нь түлээ түлшний дэмжлэгт хамрагдахаар байна. Аймаг болон ЗГХА ГБХЗХГ-т байгууллагын хяналтад байх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 22 төрлийн тайланг хүргүүлэн ажиллав. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг 11 дүгээр сарын байдлаар 32 өрхийн 49 хүүхдэд үзүүлсэн байна.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний шинэчилж, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан нийт 22 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний биелэлт 75,9%-тай байна. Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр штабт 09.00-22.00 цагийн хооронд хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ЭМГ-ын дэргэдэх “Эх, хүүхдийн баг” Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдад ажиллаж ба 2020 ны 06 сард ЭМГ-ын эмч, мэргэжилтнүүд дэмжлэгт хяналт хийсэн ЭМГ-ын даргын 673 тоотойр албан бичгээр зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажилд гүйцэтгэлийн үнэлгээ хийлээ.

Аймгийн Онцгой комиссын даргын баталсан удирдамжийн дагуу Коронавируст халдвар “COVID19”-ын Бүх нийтийн бэлэн байдал зарласан үед ЭМБ-ын бэлэн байдлыг хангуулах чиглэлээр Жаргалант, Галт, Шинэ-Идэр сумдад Онцгой байдлын газрын мэргэжилтэн, хэсгийн ахлагч нартай хамтран 2020 оны 11 дүгээр сарын 19-21 хүртэл зөвлөн тусалж ажиллалаа.

Улсын хэмжээнд дотоодод халдвар бүртгэгдэж, улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрээр хатуу хөл хориог 2020 оны 11 дүгээр сарын 12-ноос 12 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд тогтоосонтой холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын А/84-дүгээр тушаалаар Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн. Уг тушаалын дагуу Эрүүл мэндийн газраас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад тусгайлан бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд цахим сургалтыг өдөр бүр зохион байгуулан ажиллалаа. Сургалтыг нийт 39 сэдвийн хүрээнд 17 эмч, мэргэжилтнүүд орж, эрүүл мэндийн байгууллагуудын санал бодлыг сонсон аргагүйн зөвлөгөө өгч ажилласан. Сургалтад нийт 29 эрүүл мэндийн байгууллагуудын давхардсан тоогоор 3141 хүн хамрагдлаа.

Мэргэжлийн хяналтын газар коронавируст халдварын үед болон, урьдчилан сэргийлэх чиглэлийн хяналт шалгалтыг Улсын онцгой комиссын даргын 20 дугаар удирдамжын хүрээнд МХЕГазрын даргын 247,248,249 дүгээр удирдамжаар:

1. Хүнсний үйлдвэр, Худалдаа, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхлэгч 820 иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, 374 аж ахуйн нэгж байгууллагын 22910 мкв талбайд мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэлийг хийлгэж хяналт тавин ажиллаж байна.

2. Ундны ус хангамжын 25 худаг бохир ус цэвэрлэх 1 байгууламжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж мэргэжлийн хяналтын лабораторид 25 дээжийг шинжилгээнд өгч үлдэгдэл хлорыг тодорхойлуулсан. Шаардлага хангаагүй дээж бүртгэгдээгүй.

3. Коронвируст халдварын үед эмнэлэгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн аймгийн нэгдсэн эмнэлэгийн бэлэн байдлын 74,6%хувьтай шалгагдсаныг бэлэн байдлыг хангуулах нөөц бүрдүүлэх чиглэлээр улсын байцаагчын 2 зөвлөмжийг өгч аймгийн онцгой комисст тодорхой саналуудыг хүргүүлж ажилласан.

4. Газрын тосны бүтээгдэхүүний худалдаа, түлшний хангамжын үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад албан хаагчдын эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, бие засах гар угаах орчны бүрдүүлэх, халдваргүйжүүлэх бодисыг хэрхэн ашиглах, нөөц бүрдүүлэх зэрэг улсын байцаагчын хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

5. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн мөрдөх чиглэлээр улсын байцаагч нар 16 чиглэлийн зөвлөмжийг гаргаж чиглэл бүрт цахимаар болон биечлэн нийт 3000 гаруй байгууллага, иргэнд хүргүүлж зөвлөмжийн хэрэгжилтэнд цахимаар болон биечлэн хяналт тавин ажиллаж байна.

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:**

2020 оны 11 сарын нийгмийн халамжаар 63649 хүнд 22,840,786,435 төгрөгийг олголоо

“ЦАХИМ МОНГОЛ” хөтөлбөрийн хүрээнд ehalamj -г нэвтрүүлсэн 2 сар болж байгаа бөгөөд нийт халамжийн үйлчилгээ сар бүр авдаг иргэдийн 95,8 хувь нь тухайн үйлчилгээгээ дансанд холбуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг аж ахуйн нэгжид 3,8 сая төгрөгийн ажил олгогчийн урамшуулалыг олгосон.

2020 онд малжуулах хөтөлбөрт хамрагдсан 25 иргэнийг Улаанбаатар хот болон Төв аймгийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа ААНБ, малын түүхийн эд боловсруулах үйлдвэрүүдтэй танилцуулсан. Мөн мал маллагааны сургалтанд 2 өдөр хамруулсан. Уг туршлага судлах арга хэмжээнд 12,4 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан байна.

### **СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Нийтийн уншлагын танхимаас “Шинэ номын үзэсгэлэн”, “Монгол Улсын Төрийн шагналт, Ардын Уран зохиолч Бавуугийн Лхагвасүрэнгийн мэндэлсний 75 жилийн ойд “Гэрээр ном олгох” уншлагын танхимаас СГЗ зохиолч, яруу найрагч Г.Аюурзанаын уран бүтээлээс үндсэн фондоос шинэ номын үзэсгэлэнг цувралаар гаргаж уншигчдад сурталчлан ажиллалаа. Монгол Улсад шинэ үндсэн хууль батлагдсаны 28 жилийн ойг тохиолдуулан уншигчдад үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал, хэм хэмжээг танин мэдүүлэх зорилгоор уншлагын 3 танхимд “Таны эрх зүйн мэдлэг”, “Шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт”, “Миний үндсэн хууль-Миний эрх чөлөө” номын үзэсгэлэнгаргалаа.

“Шинэ Мөрөн” худалдааны төвд нүүдлийн номын сан ажиллууллаа. Нүүдлийн номын сангаар 14 шинэ уншигчид карт нээж, шинэ номын үзэсгэлэнг 50 номоор гаргаж, 60 гаруй уншигчид хүргэлээ.

ОНСМ, Хилийн цэргийн 0257 дугаар ангийн Соёлын төвтэй хамтран соёл, олон нийтийн ажлын нээлтэд хамтран оролцож хил хамгаалалтын талаар мэдээлэл сонсож, соёлын өв, музейн талаар мэдээлэл хийж харилцан мэдээлэл солилцож, хилийн цэргийн холбогдолтой үзмэрээр үзэсгэлэн гаргаж, анги бүрэлдэхүүнд музейн үзүүлэг үнэ төлбөргүй үзүүлж хамтран ажиллалаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 28 жилийн ойд зориулан музейн үзмэрээр танилцуулга булан гаргаж иргэд, төрийн байгууллагуудад үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүллээ.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

Ханх, Рэнчинлхүмбэ, Цагааннуур, Цагаанүүр, Улаан-Уул сумдад 10-15 см цастай, бусад нутгаар 5-10 см цастай байна. Хүйтний эрч нэмэгдэж байна. Ханх, Рэнчинлхүмбэ сумын зарим багт бэлчээрийн ургац тааруу байсантай холбоотой цас нэмж орвол мал өвөлжилт хүндэрч магадгүй бусад нутгаар өвөлжилт хэвийн байна.

**Оторт:** Аймгийн 19 суманд 237 өрхөд өндөр настай 60, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 12, жирэмсэн 2, хүүхэд 257 нийт 760 иргэн, 104885 толгой мал, гадна аймгийн нутагт Цэцэрлэг, Жаргалант, Галт сумаас Завхан, Архангай, Баянхонгор, Хэнтий, Булган аймагт 26 малчин өрхийн нийт 69 иргэнээс өндөр настан 1, хөгжлийн

бэрхшээлтэй иргэн 3, хүүхэд 19, 9613 толгой мал, Булган аймгаас Их-Уул суманд 2 малчин өрх 4 хүүхэд, 4малчин, 909 толгой мал отроор өвөлжиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 63 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу отор нүүдлээр өвөлжиж байгаа малчин өрхийг тухайн очсон сумын Засаг дарга нарт төрийн үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах талаар санал хүргүүлсэн. Мөн отроор өвөлжиж байгаа малчин өрхийн дэлгэрэнгүй судалгааг хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Аймгийн аварга малчин гэр бүл, Аймгийн хошой аварга малчин гэр бүл, Аймгийн аварга цаатан гэр бүл, Аймгийн аварга саальчин, Аймгийн аварга фермер, Аймгийн залуу аварга гэр бүл шалгаруулах журмыг хэлэлцүүлэн батлуулсан.

Хөвсгөл лайк компаний санхүүжилтээр нийт 24 сумын малын эмч мэргэжилтэн нарт “Цахим мал эмнэлэг” цаг үеийн байдлаар сургалт семнар хийлээ. Энэ сургалтанд нийт 170 мэргэжилтэн хамрагдаж, 8 сая төгрөгийг зарцуулсан.

23 сум 1 тосго, аймгийн мал эмнэлгийн газрын 4 нийт 48 мэргэжилтэн "Шинэ болон дахин сэргэж буй өвчнүүд" ийн талаарх малын эмч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх 8 цагийн багтаамжтай 5 сэдэвт агуулгаар 1 кредит цагийн сургалтанд хамрагдаж 30 мэргэжилтэн гэрчилгээ авсан байна.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж байна. Энэ арга хэмжээнд өнөөдрийн байдлаар 4,5 сая төгрөг зарцуулсан.

<b>Халдваргүйтгэлийн объектийн нэр, төрөл, тоо, хэмжээ /м<sup>2</sup>/</b>							
Нийтийн эзэмшлийн талбай /м2/	Мал, мах бэлтгэх цэг	Байр, оффис	Агуулах	Муу усны нүх, жорлон	Бусад	Тээврийн хэрэгсэл тоо	Нийт талбай /м2/
<b>12038.5</b>	<b>2744</b>	<b>18708</b>	<b>893</b>	<b>2141</b>	<b>1594</b>	<b>240</b>	38118.9

#### **Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:**

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 500 сая.төгрөгийг 7 иргэнд олгохоор дэд хорооны шийдвэр гарсан бөгөөд үүний дагуу холбогдох бүх бичиг баримтыг бүрдүүлэн Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх санд хүргүүллээ.

Онлайнаар 21 аймгийн жижиг, дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэнүүдийн дунд 7 хоногын хугацаанд “Бүтээгдэхүүний стандартын баталгаажуулалт аудит хийх аргачлал” сэдэвт сургалтанд хамрагдсан.



Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан өдөр бүр 11 цагаас 23 сум 1 тосгоноос мэдээг авч нэгтэн аймгийн шуурхай штаб болон Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шуурхай штабд хүргүүлэн ажиллаж байна.

МХЕГ-тай хамтран зоорь, агуулах болон төмс хүсний ногооны нөөцийн судалгааг дэлгэрэнгүй үнэн бодитоор гаргахаар 11 дүгээр сарын 14-ний өдөр 28 ААН, иргэнээр орон мэдээллийг авч нэгтгэн ажилласан.

Үр тарианы хураалт болон төмс хүсний ногооны хураалтын мэдээ, энэ оны ургацаас нөөцөлсөн төмс, хүсний ногооны мэдээллийг гаргаж Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

### **Зургаа.Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

2021 онд тусгай зориулалтаар болон ахуйн зориулалтаар агнах барих амьтны тоо хэмжээний саналыг БОАЖЯаманд хүргүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай хүнд үйлвэрийн сайд нарийн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг гаргаж холбогдох яамдад нь хүргүүллээ.

Азийн хөгжлийн банкны 19 сая долларын санхүүжилтээр хэрэгжих тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн баг 11 дүгээр сарын 5-9-ний хооронд Мөрөн сум, Хатгал тосгонд ажиллаж дараах ажлуудыг зохион байгууллаа.

Аймгийн удирдлагууд, холбогдох албаны хүмүүстэй нэгдсэн уулзалт зохион байгуулсан.

Хатгал тосгоны, ХНБЦГ-ын төлөөлөлтэй уулзаж ХНБЦГ-ын менежментийн төлөвлөгөө, аялал жуулчлалын дэд зөвлөл байгуулах талаар хэлэлцүүлэг хийсэн.

Хатгал-Хүзүүвчийн шил чиглэлийн 5,5 км замын трассын, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ, холбогдох байгууллагуудын санал авсан.

Хатгал Жанхай Тойлогт чиглэлийн 30,4 км Мөрөн Хатгал чиглэлийн авто замаас Хатгал Жанхай Тойлогт чиглэлийн авто замтай холбох 2 км авто зам, Шалган нэвтрүүлэх цэгийн барилга, зогсоолын байршлыг тогтоосон.

Хатгал тосгонд байрлах 2 авто зогсоол, ариун цэврийн байгууламж байгуулах

Хатгал тосгоны төлбөр авах цэгийн судалгааг хийсэн.

**Аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцлоо:** БОАЖЯ, Монголын аялал жуулчлалын холбооноос уламжлал болгон зохион байгуулдаг ITM MONGOLIA 2020 аялал жуулчлалын үзэсгэлэн 10 дугаар сарын 28-аас 11 дүгээр сарын 01 –ны хооронд зохион байгуулагдлаа. Манай аймгаас аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо, аялал жуулчлал зочлох үйлчилгээний холбоо хамтран нийт 96 м2 талбайг тохижуулан аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ сурталчлан оролцлоо. Үзэсгэлэнд

Далай тур, Байгаль-Үүд, Хөвсгөл далай, Капитан, Алагцар, Наран зангилаа, Хөвсгөл сор, Хөх сувд, Далайн гялбаа, Баян –Улаан, Эг тур, Гурван-Эрдэнэ, Далай ээж, Хөвсгөл далай, Далайн гялбаа, Тойлогт, К2, Гурван эрдэнэ 18 жуулчны бааз, Хатгал гар урлал бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид 3 иргэн оролцож сурталчилгаа хийлээ. MONGOLIA ITM 2020 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн БОАЖГ-аас аймгийн ХДТ-ын 2 уран бүтээлчийн томилолт, тараах материал, брошур альбом, ил захидал зэрэг 600,0 / зургаан зуун мянган төгрөг/-ийн зардлыг гаргаж оролцлоо. Мөн аймгийн ХДТ-ын дуучин Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан н.Амарсайхан, дуучин, хөөмийч н.Төмөр-Очир нар оролцож исгэрээ, хөөмий, хархираа, урианхай ардын дуу “Самгалдай”, дархад ардын дуу “Уйтан хогорго хангай”, “Жангас тайга” зэрэг дуугаар урлагийн мэндчилгээ хүргэлээ.

“Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдад тогтвортой хөгжлийн боловсрол олгох арга зүй, туршлага” сэдэвт онол, практикийн бага хурлыг БСУГ, БОАЖГ хамтран зохион байгуулж, эхний шатанд 13 илтгэл ирж, 2 дугаар шатанд 8 шилдэг илтгэл шалгарсан ба шилдэг 8 илтгэлийг оролцогчид онлайнаар танилцуулсанаар эхний 4 байр шалгарууллаа. 1-р байранд ДМЦС-ийн бага ангийн багш нар, 2-р байрт ЭДЦС-ийн дунд ангийн химийн багш нарын баг, 3-рб айрт ДМЦС-ийн байгалийн ухааны багш нарын багийн илтгэл шалгарлаа. Тусгай байранд Мөрөн Гурван-Эрдэнэ сургуулийн багш нарын баг шалгарав.

БОАЖЯ-аас санхүүжүүлж буй хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд Мөрөн сумын хогийн цэгийн талбайг 10 га хумих, эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх ажлуудыг Мөрөн хот тохижилт ХХК-аар гүйцэтгүүлж хүлээн авлаа.

Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Илч түлш” аян зохион байгуулах, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр: Гэрээний дагуу 25 м3 түлшний мод нийлүүлсэн. Эдгээр 6 аж ахуй нэгжээс 5 аж ахуй нэгж 717 м3 модыг аймаг болон Мөрөн сумаас томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Худалдан борлуулагчаар ажиллаж байгаа “Шинэс” захаас 717 м3 модыг худалдан борлуулж 30.1 сая төгрөгийг Мөрөн сумын ЗДТГ-ын дансанд төвлөрүүлэн ажилласан.

Аймгийн хэмжээний мод бэлтгэлийн мэдээгээр 2020 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар хэрэглээ мод 63641 м3-ыг бэлтгэхээс 42667 м3-ыг бэлтгэж 67.1%-ийн гүйцэтгэлтэй төсөвт 382143245 төгрөг, түлээний мод 340526 м3-ыг бэлтгэхээс 165335 м3-ыг бэлтгэж 48.6%-ийн гүйцэтгэлтэй төсөвт 425080718 төгрөг төвлөрүүлсэн дүн мэдээ гарсан. Нийт дүнгээр 404167 м3-ыг бэлтгэхээс 208002 м3 мод бэлтгэж орон нутагт 778789354 төгрөг төвлөрүүлсэн бөгөөд бэлтгэх мод, орон нутгийн орлогийн төлөвлөгөөтэй харьцуулан үзэхэд мод бэлтгэл 51.5 %, орлого 73 %-ийн гүйцэтгэлтэй байна.

МИАТ компаниас орон нутагт аяллын нислэг үйлдэхээр болсонтой холбоотойгоор Хөвсгөл аймгийн танилцуулга мэдээлэл, Хөвсгөл нуур, нуурын зүүн

эрэг орчмоор аялах үзмэр, үйлчилгээ, аяллын маршрут талаарх мэдээллийг хүргүүллээ.

### **Дэд бүтэц**

Мөрөн сумын “Авто зам”-ын мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар Жугнай дэлгүүрээс Нэмэн ШТС хүртэл холбох 0,579 км холбоос зам тавих ажил дууссан. Гүйцэтгэгч “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-иас улсын комисс ажиллахад бэлэн болсон байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/442 захирамжаар байгуулагдсан “Орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмын төсөл боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны А/605 дугаар захирамжаар батлууллаа.

Аймгийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар Авто замыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 850,0 сая төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Гүйцэтгэгч компаниар Хүслэнт бүтээмж ХХК ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжиж хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан Улаанбаатар хот болон өөр аймагт саатсан иргэд орон нутагтаа ирэхтэй холбогдсон арга хэмжээг Монгол Улсын шадар сайдын 2020 оны 146 дугаар тушаалаар батлагдсан “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ын дагуу зохион байгуулах ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын А/599 дугаар захирамжийг байгуулсан.

#### **ХЯНАСАН:**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА** **Х.ГАН-ОЧИР**

#### **НЭГТГЭСЭН:**

**ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН** **Б.БАЯРМАА**